

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АЖЛЫН АЛБАНААС 2022 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН
АЖЛЫН ТАЙЛАН
/2022.01.01 - 2022.12.30-ны байдлаар/**

2022 оны 12 дугаар сарын 30

Улаанбаатар хот

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба тайлант онд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль болон холбогдох дүрэм журмуудад нийцүүлэн Хурлын үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, Хурлын хороод, Төлөөлөгчдийн идэвх санаачилгыг дэмжин, Төлөөлөгч иргэдийн хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлэн бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Тайлант онд Хурлын Зөвлөлийг шинээр байгуулж, Хурал, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, Хурлын хороодоос зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Гамшгийн эрсдлийг бууруулах, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах, Авлигатай тэмцэх, Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах болон мэргэшүүлэх сургалтын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг тус тус боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн ээлжит дөрөвдүгээр, тавдугаар, зургаадугаар, долоодугаар, ээлжит бус гуравдугаар болон хүндэтгэлийн хуралдаануудыг тус тус зохион байгуулж, дүүргийн Засаг даргаас өргөн барьсан 22 (давхардсан тоогоор), Хурлын Ажлын албанаас өргөн барьсан 12 (давхардсан тоогоор) нийт 34 асуудлыг хэлэлцэн баталлаа.

Хурлын хуралдаанаас баталсан шийдвэрийг дурдвал:

1. Дүрэм, журмууд:

- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг батлах тухай;
- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм батлах тухай;
- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дүрэм батлах тухай;
- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороог байгуулж, үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлах тухай;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах Чингэлтэй дүүргийн Зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн батлах тухай;

- Дүүргийн ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дүүргийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай;

2. Зохион байгуулалтын чиглэлээр:

- Хурлын Зөвлөл байгуулах тухай;
- Тооллогын комисс байгуулах тухай;
- Хороодын хэсгийн хуваарийг шинэчлэн тогтоох тухай;
- Чиглэл болгох тухай;
- Хаягийн бүртгэлд өөрчлөлт оруулах тухай;
- Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд иргэдийг оролцуулах тухай;
- Хурлын Ажлын албаны орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай;
- Нийслэлийн Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай;
- Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын хуралдаанд оролцох Төлөөлөгчийг сонгох тухай;
- Дүүргийн зарим орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг нэгтгэх тухай;
- Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд Эмэгтэйчүүдийн зөвлөл байгуулах тухай;
- Хамгаалалтын бүсийн хилийн цэсийн солбицол, газрын хэмжээг шинэчлэн тогтоох тухай;

3. Хяналт шалгалтын чиглэлээр:

- Дүүргийн 2022 оны хагас жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт, 2022 оны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай;
- Дүүргийн Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, 2023 оны төлөвлөгөө батлах тухай;

4. Төсөв санхүүгийн чиглэлээр:

- Дүүргийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай;
- Дүүргийн 2022 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Тогтоолд өөрчлөлт оруулах тухай;
- Дүүргийн 2023 оны төсөв батлах тухай;

5. Бусад:

- Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай;
- “Алдарт эх”-ийн одонгоор шагнуулах эхчүүдийг уламжлах тухай;
- Төрийн цол, одон медалиар шагнуулахаар уламжлах тухай;
- Төрийн дээд шагналд уламжлах тухай;

Хурлын хуралдаанаас баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд 90-100 хувь буюу бүрэн хэрэгжсэн 22, 50-90 хувь буюу хэрэгжих шатандаа 5, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 7 тогтоол байна.

Тайлант онд хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороод, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Зөвлөлийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит дөрөвдүгээр хуралдааны 05 дугаар тогтоолоор байгуулан, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан, батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Б.Мөнхбат, И.Даваадорж, Т.Уламбаяр, Ж.Булганцэцэг, Ц.Содхүү, Р.Ганболд, Л.Цэеэрэгзэн нар сонгогдон ажиллаж байна.

Хурлын Зөвлөл тайлант хугацаанд 15 удаа хуралдаж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 42 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээс 39 асуудлыг хэлэлцэж, давхардсан тоогоор зохион байгуулалтын 8, Хурлын хорооны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах 8, нийт 16 тогтоол, шийдвэрийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 92,8 хувьтай байна.

Хурлын Зөвлөлөөс баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд 90-100 хувь буюу бүрэн хэрэгжсэн 15, хэрэгжих хугацаа хойшилсон 1 тогтоол байна.

Хурлын байгууллагын тасралтгүй, байнгын, хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий Хурлын хороод тайлант хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр 71 ажил зохион байгуулахаар төлөвлөснөөс 10 удаагийн удирдамж, төлөвлөгөөний дагуу 69 ажлыг зохион байгуулж, 2 ажил хойшилж, биелэлт 97.1 хувьтай байна.

Хурлын хороодоос зохион байгуулсан ажлаас дурдвал:

Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо:

- Чингэлтэй дүүргийн ИТХ-ын хуралдааны дэгийн төсөл;
- Чингэлтэй дүүргийн ИТХ-ын Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийн төсөл;
- Чингэлтэй дүүргийн ИТХ-ын дүрмийн төсөл;
- Хурлын хороод байгуулах тухай, үйл ажиллагааны журмын төсөл;
- Чингэлтэй дүүргийн зарим хороодын хэсгийн хуваарийг шинэчлэн тогтоох тухай;
- Хаягийн бүртгэлд өөрчлөлт оруулах тухай;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах;
- Хүний нөөц, нийгмийн баталгаа 2024 арга хэмжээний явц, үр дүн;
- Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах, гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц, үр дүн;
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилт;
- Дүүргийн хороодын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа;

- Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих орон нутгийн сангийн журмын төсөл;
- Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих орон нутгийн сангийн журам батлах тухай- Нийтийн сонсгол, хэлэлцүүлэг;
- “Эрхээ мэдье-үүргээ ухамсарлая” дүүргийн аварга шалгаруулах мэтгэлцээн;

Төсөв санхүү, эдийн засаг хөгжлийн хороо:

- Дүүргийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн үйл ажиллагаа, цаашид авах арга хэмжээ;
- Дүүргийн худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагаа, цаашид авах арга хэмжээ;
- Дүүргийн ЗДТГ-ын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн үйл ажиллагаа;
- Дүүргийн Татварын хэлтсийн үйл ажиллагаа, цаашид авах арга хэмжээ;
- Дүүргийн 2021 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн, орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлж буй ажил;
- Дүүргийн 2021 оны Төсвийн гүйцэтгэл;
- Дүүргийн 2022 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөний явц;
- Дүүргийн 2022 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төсөл;
- Дүүргийн 2022 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн явц;
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилт;
- Дүүргийн 2023 оны Төсвийн төсөл;
- Тогтоолд өөрчлөлт оруулах тухай;
- Chgl.maps.mta.mn- Татварын хэлтсээс санаачлан хэрэгжүүлж байгаа татвар төлөгчийн бүртгэл, мэдээллийг боловсруулах программ;
- Дүүргийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн анхан шатны мэдлэг олгох сургалт, хэлэлцүүлэг;

Төсвийн зарцуулалтын хяналтын хороо:

- Дүүргийн Дотоод аудитын албаны үйл ажиллагаа, 2021 оны Төрийн аудитын тайлан, зөвлөмжийн хүрээнд хийгдсэн ажил;
- Дүүргийн Худалдан авах ажиллагааны албаны 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт;
- Дүүргийн Татварын хэлтсийн үйл ажиллагаа, цаашид авах арга хэмжээ;
- Дүүргийн ОНХС хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэл;
- Дүүргийн 2021 оны төсвийн гүйцэтгэл;
- Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр хийгдэх ажлын явц, гүйцэтгэл;

- Улс, Нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүрэгт 2021 онд хийгдсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, 2022 он, 2021-2022 он дамжин хийгдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний явц, хэрэгжилт;
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилт /харьяалах асуудлаар/
- Дүүргийн 2023 оны төсвийн төсөл;
- Дүүргийн 2022 оны төсвийн нэмэлт, өөрчлөлт;
- Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, 2022 оны төсвийн төлөвлөгөө, санхүүгийн гүйцэтгэлийн мэдээг www.shilendans.gov.mn сайтад хуваарийн дагуу байршуулж байгаа эсэхэд хяналт тавих, санал дүгнэлт боловсруулах;
- Төрийн аудитын дүгнэлттэй танилцах, дүгнэлтийн хүрээнд хийгдсэн ажил;
- Дүүргийн төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа;

Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хороо:

- Хорооны эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, албадын үйл ажиллагаатай танилцах;
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хүүхэд хамгааллын чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөлт, явц, хэрэгжилттэй танилцах;
- Дүүргийн төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаатай танилцах;
- Дүүргийн хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөлт, явц, хэрэгжилттэй танилцах;
- “Эрүүл Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээний хэрэгжилт, явц, үр дүн;
- “Чадварлаг багш-2024” арга хэмжээний хэрэгжилт, явц, үр дүн;
- “Гэр бүл-2024” арга хэмжээний хэрэгжилт, явц, үр дүн;
- “Соёлтой иргэн-2024” арга хэмжээний хэрэгжилт, явц, үр дүн;
- Дүүргийн ЕБС, СӨБ-ын 2022-2023 оны хамран сургах тойрог, хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилтай танилцах;
- Дүүргийн Залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөлт, явц, хэрэгжилттэй танилцах;
- Бүх нийтийн биеийн тамир, спорт, соёл урлагийг дэмжих чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөлт, явц, хэрэгжилттэй танилцах;
- Ахмад настны нийгмийн хамгааллын чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөлт, явц, хэрэгжилттэй танилцах;
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилттэй танилцах /харьяалах асуудлаар/;

- МУЗГ-аас хэрэгжүүлж буй Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд “Хороодын өрхийн эрүүл мэндийн төвийн цахим бүртгэл, өвчний түүх, эмчийн жор, үзлэгийн мэдээллийн сан бүхий бүртгэл, мэдээллийн систем төсөл”;
- “Нийгмийн ажил-Мэргэжлийн үйлчилгээ” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг;

Ногоон хөгжил, газрын харилцааны хороо:

- ЗДТГ-ын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн үйл ажиллагаатай танилцах;
- Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны үйл ажиллагаатай танилцах;
- Чингэлтэй хайрхны ойжуулалт, булаг шандын хамгаалалтын үйл ажиллагаатай танилцах;
- Дүүргийн агаар хөрс, орчны бохирдол, цаашид авах арга хэмжээтэй танилцах;
- Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн арчлалт, хамгаалалт, байгаль хамгаалал, нөхөн сэргээх чиглэлээр хийгдэж буй ажлын явц байдалтай танилцах;
- Зуслангийн бүсэд орц гарц, гаргах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Ногоон дүүрэг 2024 арга хэмжээний явц, үр дүн;
- “Найши трейд” ХХК, “Чингэлтэй дүүргийн ТҮК” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцах;
- Зарим хороодын нутаг дэвсгэрийн заагийн тухай;
- Газар чөлөөлөлтийн ажлын явц, мэдээлэл;
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилттэй танилцах /харьяалах асуудлаар/
- Дүүргийн газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөний биелэлт, 2022 оны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай;
- Дүүргийн Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний төсөл;

Хот байгуулалт, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо:

- Чингэлтэй дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Чингэлтэйд үйлдвэрлэв цэгүүдийн үйл ажиллагаатай танилцах;
- Хог хаягдлын менежмент, гэрэлтүүлэг, камержуулалтын чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөлт, түүний явц, гүйцэтгэлтэй танилцах (Чингэлтэй тохижилт үйлчилгээний компани, Соён дрийм ХХК, Найши трейд ХХК)
- Дүүргийн нутаг дэвсгэрт ахуйн үйлчилгээ, авто үйлчилгээ, үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн аж ахуйн нэгж байгууллагад цахим системд бүртгүүлэх, үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах;

- Хүнсний бүтээгдэхүүний хяналт, аюулгүй байдлын талаар баримталж буй бодлого үйл ажиллагаатай танилцах;
- Гэр хорооллын хөгжлийн бодлого үйл ажиллагаатай танилцах;
- Авто зам, явган замын засварын ажил, цахилгаан эрчим хүч, хаягжилтын ажлын чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөлт түүний явц, гүйцэтгэлтэй танилцах;
- Чингэлтэйд үйлдвэрлэв 2024 арга хэмжээний явц, үр дүн;
- Бүтээлч Чингэлтэйчүүд 2024 арга хэмжээний явц, үр дүн;
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилттэй танилцах /харьяалах асуудлаар/
- Чингэлтэйн хог баялаг болно-төсөл;
- Хороодын хэсгийн ахлагчдыг сургагч багшаар бэлтгэх-төсөл;

Ёс зүй, өргөдлийн хороо:

- Иргэд, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц байдалтай танилцах;
- Иргэдийн оролцоог хангах чиглэлээр зохион байгуулж буй ажилтай танилцах;
- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн хорооны үйл ажиллагаатай танилцах;
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, хэрэгжилттэй танилцах /харьяалах асуудлаар/
- Дүүргийн төрийн албан хаагчид болон иргэдийн хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн хэлэлцүүлэг;

Тайлант онд Хурлын хороодоос зохион байгуулсан онцлог ажлаас дурдвал:

Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооноос “Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих орон нутгийн сангийн журмын төсөл”-д санал авах зорилгоор Хурлын Төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон дүүргийн 1-24 дүгээр хорооны иргэдийн дунд нийтийн сонсгол, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хорооны санаачилгаар Эрүүл мэндийн анхан шатны байгууллага болох хороодын Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээг цаасан хэрэглээнээс цахим хэрэглээнд шилжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, үзлэгийн бүртгэл мэдээллийн цахим системийг бий болгож, эрүүл мэндийн цахим бүртгэл, өвчтөний түүх, эмчийн цахим жор, үзлэгийн мэдээллийн сан бүхий бүртгэл мэдээллийн системийг дүүргийн 9, 12, 15, 16 дугаар хороодын ӨЭМТ-үүдэд нэвтрүүллээ.

Мөн Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооны санаачилгаар Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг илрүүлэх, далд эдийн засгийг бууруулах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, татвар төлөгчдөд зөвлөгөө мэдээлэл

өгөх зорилго бүхий татвар төлөгчдийн бүртгэлийн chgl.maps.mta.mn нэгдсэн системийг нэвтрүүлээд байна.

Хот байгуулалт, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хорооноос хог хаягдлыг ангилан ялгаж, байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн “Чингэлтэйн хог баялаг болно” 3 сарын хугацаатай төслийг хэрэгжүүлж, дүүргийн 1-24 хорооны 180 хэсгийн ахлагч нарыг хог хаягдал, байгаль хамгаалах сургагч багшаар бэлтгэлээ.

Дээрх төслийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулан үр дүнг тооцон ажилласан байна. Үүнд:

- Дүүргийн 1-24 хороодын Иргэний танхимаар “Чингэлтэйн хог баялаг болно” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн ажил;
- “Цэвэр хот, хотоо хайрлая” дууг хэн сайн дуулах вэ хүүхдийн дууны сошиал уралдаан;
- Хэсгийн ахлагч нарын дунд “Манай хэсэг хогоо ангилдаг” уралдаан;

ХОЁР. ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ

Хурлын Төлөөлөгчдийн иргэд, сонгогчидтойгоо ажиллах нөхцөлийг бүрдүүлж, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх хүрээнд: “Эртэч Чингэлтэйчүүд”, “Анзаар” 2 удаагийн аян, Үндсэн хуулийн өдөр, Сар шинэ нэгдсэн арга хэмжээ, Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр, Монгол Улсын иргэний андгай өргөх ёслол, Хичээлийн шинэ жилийн нээлт, “Ногоон бүс” теле хяналтын камерын нэгдсэн төвийн нээлт, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд”-ийн аварга шалгаруулах тэмцээн, “Улаанбаатар марафон 2022” олон улсын гүйлт, “Хангарди-2022” спорт наадам, Чингэлтэй хайрхны тахилга, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, бүх нийтийн мод тарих арга хэмжээ, “Дээлтэй Монгол наадам-2022”, “Дүүргийн хөгжилд залуучууд бидний оролцоо” сургалт өдөрлөг нийт 15 удаагийн төвлөрсөн арга хэмжээ, Бүгд Найрамдах Турк, Солонгос, Япон Улсад айлчлах 3 удаагийн гадаад арга хэмжээ, “Олон Улсын Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх нь” сургалт хэлэлцүүлэг, Швейцарын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Данийн Ковин болон Икон ХХК-ны хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн менежмент” төслийн хүрээнд зохион байгуулагдсан “Хог хаягдлын менежментийн санхүүгийн зохицуулалт” сургалт, хэлэлцүүлэг, “Хамтын ажиллагаа, түншлэлийг сайжруулах нь Ажил олгогч эздийн зөвлөгөөн”, “Төр иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны уулзалт, нийгмийн эгэх хариуцлагын сургагч багш бэлтгэх” төсөл, “Хүний эрх ба жендер” сургалт нийт 4 удаагийн сургалт зөвлөгөөнд, “Хөдөлгөөнөө эрчимжүүлье” нетворк уулзалт, нийт 24 сургалт, арга хэмжээ, уулзалт хэлэлцүүлэгт Хурлын Төлөөлөгчдийг оролцууллаа.

Мөн Хурлын Төлөөлөгчдийг цаг үеийн мэдээ, мэдээллээр шуурхай хангах чиглэлээр “Мэдээллийн цаг” арга хэмжээг сар тутамд, тогтмол зохион байгуулж, хэвшлээ.

Тайлант хугацаанд Хурлын Төлөөлөгчид дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, Татвар, Онцгой байдал, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсүүд болон дүүрэг дэх Цагдаагийн газар, Эрүүл мэндийн төв, Газар зохион байгуулалтын алба, Хүүхдийн номын өргөө, Тохижилт, үйлчилгээ, Наша Трейд, Соён дрийм ХХКомпаниуд, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, Теле хяналтын камерын нэгдсэн төв, Олон Улсын Монтесори, Стийм, Аймбрийк хөтөлбөр хэрэгжүүлж байгаа Чингэлтэй дүүргийн 103, 280, 293 дугаар цэцэрлэгүүдийн үйл ажиллагаатай Мэдээллийн цаг арга хэмжээний хүрээнд танилцлаа.

Тайлант онд Хурлын Төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тэдний тойрогтоо ажилласан байдлыг харгалзан Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолыг үндэслэн жилд нэг удаа, үйл ажиллганы зардал болон Хурлын Зөвлөлийн гишүүдийн урамшууллыг сар тутам, Хурлын хороодын үйл ажиллагааны зардлыг тухай бүр Хурлын төсвөөс тус тус санхүүжүүлж ажиллалаа.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дэвшүүлсэн зорилт, Хурлын байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах хүрээнд иргэд, олон нийтэд чиглэсэн, үр дүн бүхий сургалт, үйл ажиллагаа, арга хэмжээнд Хурлын Төлөөлөгчдийг тухай бүр хамруулан, хамтран ажиллалаа. Үүнд:

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсад Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсны 30 жилийн ойг тохиолдуулан Үндсэн хууль батлалцсан Чингэлтэй дүүргийн харьяат, тухайн үеийн Ардын Их Хурлын депутатаар ажиллаж байсан Д.Мандах, Л.Дашням, М.Шийрав, Н.Гаравсүрэн, Т.Жагай нарыг хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.

Сар шинийн баярыг тохиолдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд болон хороодын Иргэдийн Нийтийн Хурлын 13 ахмад дарга, дүүргийн харьяа ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардууллаа.

Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх, ганцаарчилсан уулзалт ярилцлага хийх, хүчирхийллээс өөрийгөө болон бусдыг хамгаалах урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгох “Сэтгэл зүйн дархлаа” арга хэмжээг дүүргийн 1-24 хорооны зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээнд 160 гаруй эмэгтэй хамрагдлаа.

Мөн “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх” Олон Улсын өдрийг тохиолдуулан хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, тэдний дуу хоолойг сонсох, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар гэр бүл, олон нийтэд зөв хандлагыг бий болгох “Шийтгэл бол шийдэл биш” сарын аяныг дүүргийн хэмжээнд зохион байгууллаа. Тус

аяны хүрээнд 5 удаагийн танхимын сургалтад 1800 гаруй сурагч, эцэг, эх, асран хамгаалагчийг, 4 удаагийн хэлэлцүүлэг, чуулганд 27 мянга гаруй сурагчдыг тус тус хамруулж, хүүхэд хамгааллын чиглэлээр 4 удаагийн шторк, 8 удаагийн постер мэдээллийг бэлтгэн, цахимаар түгээж сурталчилсан бөгөөд дүүргийн 30 мянга гаруй иргэдийг тус нөлөөллийн ажилд хамруулсан байна.

Олон Улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан хүүхдийн дотоод ертөнц, хүсэл мөрөөдлийг тэдний нүдээр харах, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй бүтээлч байдлаар илэрхийлэхийг дэмжих зорилгоор “Хүүхдийн ертөнц” сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны албан хаагчдын 25 хүүхэд хамрагдлаа.

Олон Улсын Гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд гэр бүлийн дулаан уур амьсгал бий болгох, үнэ цэнийг нэмэгдүүлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг таниулах, үр хүүхдээ үл хайхрахаас урьдчилан сэргийлэх, эерэг аргаар хүмүүжүүлэх мэдлэг олгох зорилгоор “Яг одооноос гэр бүлдээ” арга хэмжээг дүүргийн Төрийн албан хаагчдын дунд зохион байгууллаа.

Олон Улсын Залуучуудын өдрийг тохиолдуулан залуучуудыг хөгжүүлэх, амжилтад хүрэх сэтгэлзүйг нэмэгдүүлэх, зорилго бүхий “Дүүргийн хөгжилд залуучууд бидний оролцоо” өдөрлөгийг дүүргийн 18-35 насны залуучуудын дунд зохион байгуулж, 1-24 хорооны 120 гаруй залуучууд хамрагдлаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан Чингэлтэй дүүргийн харьяат улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэд, тэдний гэр бүл, үр хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Түвдэнпэлжээлин хийдтэй хамтран зохион байгуулж, хэлмэгдэгсдийн хойдын буянд зориулж зул өргөн, буяны ном хуруулж, хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг гардууллаа. Тус үйл ажиллагаанд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн үр хүүхэд, тэдний гэр бүл нийт 161 иргэн оролцлоо.

Олон Улсын Ахмадын өдрийг тохиолдуулан “Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэн шалгаруулах журам”-ын хүрээнд дүүргийн Ахмадын хороо, Хурлын Ажлын алба хамтарсан бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж ахмадын байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцож, ахмадуудад дэмжлэг туслалцаа үзүүлсэн Чингэлтэй дүүргийн 1, 8, 10 дугаар хорооны нийт 3 аж ахуйн нэгж байгууллагыг “Ахмад настанд ээлтэй байгууллага”-аар, 1, 8 дугаар хорооны 2 иргэнийг “Ахмад настанд ээлтэй иргэн”-ээр тус тус шалгаруулж, шагнаж урамшуулсан байна.

Мөн өдрийг тохиолдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд болон Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын 7 ахмад дарга нарт хүндэтгэл үзүүлж, хүлээн авах арга хэмжээг зохион байгууллаа.

Монгол бахархлын өдрийг тохиолдуулан монгол ёс заншлыг сурталчлах хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудын дунд ангийн сурагчдын дунд

“Чингэлтэй миний нүдээр” сэдэвт гар зургийн уралдаан, ахлах ангийн сурагчдын дунд “Монгол бахархал” эсээ бичлэгийн уралдааныг тус тус зохион байгуулж, нийт 243 сурагч оролцлоо.

Нийслэлийн Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойн хүрээнд дүүргийн харьяат 16 насанд хүрч буй хүүхдүүдэд иргэний эрх, үүрэг, хариуцлагыг ухамсарлах, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор “Иргэний андгай өргөх ёслол”-ыг зохион байгуулж, 200 хүүхэд хамрагдсан байна.

Дүүргийн хэмжээнд “Ном хандивлах 7 хоног”-ийн аяныг өрнүүлж, байгууллага иргэдээс ирүүлсэн 1000 ширхэг номыг дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэдэх “Гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв”-д хандивлалаа.

Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Ажлын албаны ажилтнуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Хангарди-2022”, дүүргийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын “Спорт наадам-2022” тэмцээнүүдэд тус тус амжилттай оролцлоо.

Бүх нийтийн биеийн тамир, спортыг дэмжих хүрээнд жил бүр зохион байгуулагддаг “Улаанбаатар Марафон-2022”-ийн тэмцээнд Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны ажилтан албан хаагчид оролцлоо.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн удирдамжийн хүрээнд Монгол Улсын шинэ үндсэн хууль батлагдсан өдрийг угтаж дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэрэмжит шатар сонирхогчдын “Дүүргийн аварга” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, тус тэмцээнээс шалгарсан эрэгтэй 6, эмэгтэй 3 шилдэг шатарчдыг Нийслэлийн шатар сонирхогчдын аварга шалгаруулах тэмцээнд оролцуулахаар нэрсийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүллээ.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба тайлант хугацаанд 64 ажил зохион байгуулахаас 61 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 3 ажил цаг үеийн байдлын улмаас хойшилж, биелэлт 95.3 хувьтай байна.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Тайлант онд Хурлын Ажлын алба Хурлын хороодын хуралдааны бэлтгэл ажил, хуралдаанаас гарах шийдвэрийн төслийг боловсруулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, Хурлын Төлөөлөгчдийн хуралдаа ажиллах нөхцөл бололцоог хангах, техник зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлэх, зохион байгуулсан ажлыг иргэд олон нийтэд сурталчлах, төвлөрсөн болон хяналт шалгалтын бусад арга хэмжээг зохион байгуулах, Хурлын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, төсөв санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүргийн дагуу ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд Хурлын Ажлын албанд байгууллага, иргэдээс цахим болон албан бичгээр нийт 516 бичиг тоот хүлээн авснаас 501 бичиг тоотыг хуульд

заасан хугацаанд бүрэн шийдвэрлэж, 15 бичиг шийдвэрлэх шатандаа байна. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 580 бичиг тоотыг хүргүүлэн ажиллалаа.

Ирсэн бичгийг ангилбал:

- Дээд газраас -41
- Хурлын хороод, Төлөөлөгчдөөс- 46
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх, харьяа хэлтэс албад-71
- Дүүргийн Засаг дарга түүний Тамгын газар-104
- Дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх, харьяа хэлтэс албад, хороодоос-182
- Аж ахуйн нэгж, Төрийн бус байгууллагаас-53
- Бусад-19

Хурлын Ажлын алба байгууллага, иргэдээс 8 хүсэлт, 3 өргөдөл, 1 талархалыг хүлээн авснаас 1 өргөдлийг Хурлын Ажлын алба эрхлэх асуудлын хүрээнд бүрэн шийдвэрлэж, 10 хүсэлт, өргөдлийг дүүргийн Засаг дарга түүний Тамгын газарт шилжүүлсэн байна.

Шашин сүм хийдтэй харилцах чиглэлээр дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудын судалгааг жил тутам шинэчлэн боловсруулж, мэдээллийн санд бүртгэн ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 45 байгууллага шашны үйл ажиллагаа явуулж байгаагаас Будда 17, Христ-20, Монгол зурхай 1, Бусад 7 байна.

Тайлант хугацаанд шашны байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулахыг хүссэн 9 байгууллагын өргөдөл, хүсэлтийг судлан, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дэмжин уламжиллаа.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Төрийн дээд шагнал, цол, одон, медиалаар шагнуулахаар байгууллага, иргэдээс ирүүлсэн Чингэлтэй дүүргийн харьяат 739 иргэн, “Алдарт эх” 1, 2 дугаар зэргийн одонгоор шагнуулахаар болзол хангасан Чингэлтэй дүүргийн харьяат 498 эхийн тодорхойлолт материалыг тус тус хэлэлцэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дэмжин уламжиллаа.

Дүүргийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулан, идэвх санаачилгатай ажиллаж байгаа Чингэлтэй дүүргийн харьяат 639 иргэний тодорхойлолт материалтай танилцаж 510 иргэнийг Хурлын дээд шагнал “Чандмань одон”-оор, 129 иргэнийг “Хүндэт өргөмжлөл”-өөр тус тус шагнаж урамшууллаа.

Тулгар төр байгуулагдсаны 2230, 2231 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 815, 816 жил, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойг тохиолдуулан Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны иргэн Лхамын Цэрэндондог, 17 дугаар хорооны иргэн Пүрэвийн Дагвадорж, Магсарын Тогтохбаяр нарыг, мөн дүүрэг үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ажиллаж байсан Цогтын Тунгалаг, 4 дүгээр хорооны Засаг даргаар ажиллаж байсан Авирмэдийн Тангад нарыг Чингэлтэй дүүргийн “Хүндэт иргэн”-д тус тус өргөмжлөн алдаршууллаа.

Тайлангийн хугацаанд Хурлын дарга Хурлын Ажлын албаны үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар 89 захирамж, Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга үндсэн үйл ажиллагаатай холбоотой 222, боловсон хүчинтэй холбоотой 173, нийт 395 тушаал, шийдвэрийг баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, нутгийн өөрөө удирдах байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах болон мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөг тус тус боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 375 дугаар тогтоолоор Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоосонтой холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 20 дугаар тогтоолоор Хурлын Ажлын албаны бүтэц орон тоо, ангилал, зэрэглэлийг шинэчлэн баталлаа.

Хурлын Ажлын албаны бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны ажлын байранд шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолт болон Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журмыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, шийдвэрт үндэслэн шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийн хүрээнд нийт 21 албан хаагч ажиллаж байгаагаас Төрийн захиргааны 13, Төрийн үйлчилгээний 3, Улс төрийн 4 албан хаагчтай тус тус гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээ байгуулан, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллалаа.

Тайлант онд Төрийн албаны тухай хууль болон холбогдох дүрэм журамд заасны дагуу төрийн захиргааны 1 албан хаагчийг дүүргийн Засаг даргын Тамгын газарт шилжүүлж, жирэмсний болон амаржсаны амралтын хугацаа дууссан 1 албан хаагчийг үүрэгт ажилд нь үргэлжлүүлэн, 8 албан хаагчийг төрийн албанд шинээр томилон, Ажлын албаны бүтэц орон тоонд өөрчлөлт орсонтой холбогдуулан 21 албан хаагчийг бүтцийн өөрчлөлтөөр, 6 албан хаагчийг өөрийнх нь хүсэлтээр тус тус үүрэгт ажлаас нь чөлөөлж, 2 албан хаагчид жирэмсний болон амаржсаны амралт олгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 192, 194 дүгээр тогтоолын дагуу 2 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан, Төрийн захиргааны 12 албан хаагчийн албан тушаалын ангилал зэрэглэл, Төрийн үйлчилгээний 3 албан хаагчийн цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоож, Хурлын Ажлын албанд гарсан Төрийн захиргааны 7 сул орон тоог Төрийн албаны Нийслэл дэх салбар зөвлөлийн тогтоолын дагуу нөхөж, 6 албан хаагчийн нийгмийн асуудлыг судлан шийдвэрлэж, 16 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгож, 2 албан хаагчийг “Ахлах түшмэл”-ийн мэргэшүүлэх багц сургалтад, 5 албан хаагчийг Төрийн албанд

анх томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад, 6 албан хаагчийг гадаад арга хэмжээний хөтөлбөрт тус тус хамрууллаа.

Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хүрээнд “Нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрийн нэгдсэн систем ашиглах тухай”, “Хууль, эрх зүйн мэдлэг олгох”, “Архив, албан хэрэг хөтлөлт” зэрэг цаг үеийн эрэлт шаардлага, захиалгын дагуу дээд газраас зохион байгуулсан 11 (давхардсан тоогоор) удаагийн танхимын сургалтад давхардсан тоогоор 26 албан хаагчийг, 4 удаагийн цахим сургалтад 5 албан хаагчийг, Төрийн албаны зөвлөлөөс пүрэв гариг бүр уламжлал болгон зохион байгуулж байгаа 19 удаагийн цахим сургалт болон байгууллагаас зохион байгуулсан захиалгат “Шинэ үеийн манлайлал, ур чадвар” сертификат олгох сургалтад Ажлын албаны албан хаагчдыг тус тус хамруулсан байна.

Тайлант хугацаанд Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах болон мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 20 ажлыг бүрэн зохион байгуулсан байна.

Дүүргийн гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр өгөөжтэй, нэгдмэл байх зарчмыг хэрэгжүүлэх, ижил төстэй байгууллагуудын ажлын туршлагыг судалж өөрийн ажилдаа нэвтрүүлэх хүрээнд “Гадаад дотоод хамтын ажиллагааны төлөвлөгөө” боловсруулан хэрэгжилтийг зохион байгууллаа.

Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд хамтын харилцаа бүхий Бүгд Найрамдах Солонгос, Турк, Хятад Улс, Америкийн Нэгдсэн Улс, Япон Улс болон Оросын Холбооны Улсуудын Элчин Сайдын яамд болон Япон Улсын Шизуока мужийн Яйзү, БНТУ-ын Истанбул хотын Пендик дүүргүүдтэй захидал, цахим шуудангаар байнгын харилцаатай ажиллаж байна.

Тайлант онд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Н.Батсүмбэрэл тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Солонгос Улсын Гуанжу хотод, Төлөөлөгч Н.Батсүмбэрэл тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотын Пендик дүүрэгт, Хурлын дарга Б.Мөнхбат тэргүүтэй төлөөлөгчид Япон Улсын Шизуока мужийн Яйзү хотод тус тус ажлын айлчлал хийлээ.

Айлчлалын үр дүнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Гуанжу хоттой шинээр хамтын ажиллагааг эхлүүлэх, санамж бичиг байгуулах чиглэлээр, Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотын Пендик дүүрэгтэй Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцан цаашид харилцан туршлага солилцох чиглэлээр санал солилцож, Япон Улсын Шизуока мужийн Яйзү хоттой гамшгийн эрсдэлийг бууруулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

Түүнчлэн Япон Улсын Яйзү хотын Засаг дарга Накано Хиромичи, ИТХ-ын дарга Икэгаяа Казүмаса тэргүүтэй зочид төлөөлөгчдийг тус тус Чингэлтэй дүүрэгт хүлээн авлаа.

Дотоод томилолт, арга хэмжээний хүрээнд Увс аймгийн Сагил болон Цагаанхайрхан сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүтэй зочид төлөөлөгчид, Дорноговь аймгийн Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүтэй зочид, төлөөлөгчдийг тус тус Чингэлтэй дүүрэгт хүлээн авч, харилцан туршлага солилцлоо.

Тайлант хугацаанд гадаад дотоод хамтын ажиллагааны хүрээнд 7 ажлыг зохион байгуулж, биелэлт 100 хувьтай байна.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Хурлын Ажлын албанаас зохион байгуулсан үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтэд бодитой, шуурхай, өргөн мэдээллийг тогтмол өгч ажиллах зорилгоор “Хэвлэл мэдээлэл, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

Тайлант хугацаанд Хурал, Зөвлөлөөс баталсан тогтоол шийдвэр, түүний хэрэгжилт, зохион байгуулсан үйл ажиллагаа болон цаг үеийн 305 удаагийн мэдээ, 238 цагаан мэдээ, 63 видео шторк, 88 постерыг тус тус бэлтгэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим хуудсаар, www.chingelteicouncil.mn веб сайтаар 388 мэдээ, www.chingeltei.ub.khural.mn веб сайтаар 489 мэдээ, мэдээллийг байршуулж, иргэд олон нийтэд сурталчлан ажилласан байна. Хурлын www.chingelteicouncil.mn цахим хуудсанд давхардсан тоогоор 6927, www.chingeltei.ub.khural.mn цахим хуудсанд 1,279,174, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим хуудсаар 2,049,074 хэрэглэгч хандаж мэдээлэл авсан байна.

Хурлын байгууллагаас баталсан шийдвэр, үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн цахим оролцоо, санал санаачилгыг хүлээн авах зорилгоор 1-19 дүгээр хороодын Иргэний танхимын цахим хаягт байршуулсан мэдээлэл, иргэдийн хандалтын тайланг сар бүр нэгтгэж, мэдээллийн үр дүнг тооцон ажиллаж байна. Тайлант хугацаанд Иргэний танхимын цахим хаягаар нийт 15867 удаагийн мэдээ мэдээлэл бэлтгэн нийтэлж, давхардсан тоогоор 101,433 иргэний хандалт авч, иргэд олон нийтэд сурталчлан ажиллалаа.

Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах хүрээнд Хурлын байгууллагын санхүүгийн сар, улирлын гүйцэтгэлийн тайлан, мэдээг тогтсон хугацаанд Шилэн дансанд тогтмол байршуулж, иргэд, олон нийтийн мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны 25 дугаар захирамжийн хүрээнд Төсвийн шууд захирагчийн шийдвэрээр нийт 779 зарлагын гүйлгээг анхан шатны баримт бичгийн бүрдэлд үндэслэн хийж гүйцэтгэн, мэдээ, тайланг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргүүлж, ажиллалаа.

Мөн Нийслэлийн аудитын газраас 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баримт, холбогдох хууль, Сангийн сайдын баталсан заавар, журам, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн гэж дүгнэн “Зөрчилгүй, санал, дүгнэлт” үнэлгээ авч ажилласан байна.

Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өгсөн заавар, зөвлөмжийг байгууллагын ХАСХОМ гаргагч нарт шуурхай хүргэж, шаардлагатай ном, гарын авлагаар хангаж ажиллалаа.

Тайлант хугацаанд нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын 2021 оны мэдүүлгийг цахимаар хүлээн авсан бөгөөд Хурлын Төлөөлөгч, Хурлын Ажлын албаны ажилтан, дүүрэг, хороодын Засаг дарга нийт 46 албан тушаалтныг бүртгэн, хуулийн хугацаанд нь тайлан мэдээг хүргүүлж ажиллалаа.

Авлигатай тэмцэх газар, Хурлын байгууллагаас дэвшүүлсэн зорилтод тулгуурлан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны ажлуудыг эрчимжүүлэх, Авлигын эсрэг хууль тогтоомж, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангах, албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, бүртгэл, хяналтыг сайжруулах чиглэлийн 3 бүлэг бүхий 8 ажлыг төлөвлөснөөс 7 ажил бүрэн хэрэгжиж, хэрэгжилт 87,5 хувьтай байна.

ТАВ. САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд:

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын үйл ажиллагаа:

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссоос Улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах, хэлмэгдэгчдийн нэр төрийг сэргээж, дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн ажлыг эрчимжүүлэх олон талт арга хэмжээг Улсын хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөөний хүрээнд Чингэлтэй дүүрэгт хэрэгжүүлэх ажлын 2022 оны дэд төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг зохион байгууллаа.

Тайлант хугацаанд нөхөн олговор хүссэн нийт 14 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст уламжлан, шүүхийн болон холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн 12 иргэнд 40 сая төгрөг, 2 иргэнд 80 сая төгрөгийн нөхөн олговрыг тус тус олгосон байна.

Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн бүртгэл судалгаанд хамрагдах иргэдийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч, тайлант хугацаанд нийт 161 иргэний бүртгэл судалгааг шинэчлэн баяжуулж, мэдээллийн санд бүртгэн ажиллалаа.

Түүнчлэн Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдрийн хүрээнд Хэлмэгдэгчдийн дурсгалын хөшөөнд цэцэг өргөх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, Чингэлтэй дүүргийн харьяат Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэд, тэдгээрийн гэр бүл, үр хүүхэд нийт 161 иргэнийг хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.

Мөн өдрийн хүрээнд Улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах буюу хэлмэгдэгчдийн нэр төрийг сэргээж, дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх, хэлмэгдүүлэлтийн хор уршгийг таниулахаар “Хүний эрх: Хэлмэгдүүлэлт ба Цагаатгал” сэдэвт постер сурталчилгааг бэлтгэн 1-24 дүгээр хороод, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Их дээд болон Ерөнхий боловсролын сургуулиудад байршуулж, сурталчиллаа.

Дүүргийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар зөвлөл 2022 онд нийт 7 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Гамшгийн эрсдийг бууруулах Чингэлтэй дүүргийн зөвлөлийн үйл ажиллагаа:

Хөгжлийн бодлого төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгах, бодлогын зөвлөмж, чиглэл гаргах үүрэг бүхий Гамшгийн эрсдэлийг бууруулах Чингэлтэй дүүргийн зөвлөлийн бүрэлдэхүүнд 10 байгууллагын төлөөлөл бүхий 19 хүн ажиллаж байна.

Дүүрийн хэмжээнд 2022 онд гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний чиглэлээр 3 бүлэг бүхий 17 ажлыг зохион байгуулж, хэрэгжилт 100 хувьтай байна.

Тайлант хугацаанд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиг үүрэг бүхий Онцгой байдлын хэлтэс, Улаан загалмайн хорооны ажиллах нөхцөлийг сайжруулах, сургалт сурталчилгааны ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх шийдвэрийн хүрээнд дүүргийн Улаан загалмайн хорооны хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлж, нийт 38 сая төгрөгийн дулааны шугам сүлжээний засварын ажлыг санхүүжүүлж, дүүргийн Онцгой байдлын хэлтсийн ажиллах нөхцөлийг сайжруулах хүрээнд аврах, эрэн хайх ажиллагаанд шаардагдах нисэх төхөөрөмж (дрон) иж бүрэн, суурин компьютер 3 ширхэг, зургийн аппарат 1 ширхэг, анхны тусламжийн цээж шахалтын манекен 1 ширхэг, дүүргийн аврах гал унтраах 10 дугаар ангид иж бүрэн ухаалаг дэлгэц 1 ширхэг нийт 24,8 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг тус тус худалдан авч, хүлээлгэн өглөө.

Мөн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах хүрээнд дүүргийн төрийн өмчит Ерөнхий боловсролын 19 сургууль, 37 цэцэрлэг, 24 хороод, Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Ажлын албанд тус тус гамшгийн үед яаралтай авах анхны тусламжийн иж бүрдлийг хүлээлгэн өглөө.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшгийн аюулыг иргэдэд цаг алдалгүй мэдээлэх зарлан мэдээллийн дуут дохиог дүүргийн 15, 16 дугаар хороодын нутаг дэвсгэрт байрлуулах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагаар захиалан хийлгүүлж байгаа бөгөөд ажлын явц 90 хувьтай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаа:

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2022 онд 4 бүлэг бүхий 37 ажил зохион байгуулахаар төлөвлөснөөс 36 ажил бүрэн хэрэгжиж, 1 ажил хойшилж, биелэлт 97,2 хувьтай байна.

Тайлант хугацаанд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан 17 байгууллагын төлөөлөл байхаар тогтоож, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Зөвлөлийн Ажлын албыг дарга, 2 ажилтантайгаар байгуулан, үйл ажиллагааг нь өргөжүүлэн ажиллаж байна.

Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2022 онд нийт 12 удаа хуралдаж, төлөвлөгөөт болон цаг үеийн 71 асуудлыг хэлэлцэн, 66 тогтоол, шийдвэрийг баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллалаа.

Тайлант онд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээллэх, сурталчлах, сургалт зохион байгуулах чиглэлээр дараах аян, арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архины зохисгүй хэрэглээг багасгах зорилго бүхий “Зөвийг зөвлөө” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ;
- Дүүргийн нутаг дэвсгэр дэх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, нийтийн эзэмшлийн биеийн тамирын болон тоглоомын талбай, хүүхэд тоглуулах үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд хяналт шалгалт хийх, зөрчлийг илрүүлэх, арилгуулах ажлыг зохион байгуулах зорилго бүхий “Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээ;
- “Явган зорчигчийн аюулгүй байдал-Сургууль орчмын бүс- Хүүхэд” нөлөөллийн арга хэмжээ;
- Гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг оролцуулах зорилго бүхий “Шийдвэрлэлт-2” арга хэмжээ;
- Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал эзэмшүүлэх, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг сурталчлах зорилго бүхий “Ногоон гэрэл-Цагаан шугам 2022” арга хэмжээ;

- Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах зорилго бүхий “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Ногоон дуу хоолой” 1 сарын аян;
- Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдрийг угтан “Шийтгэл бол шийдэл биш” 1 сарын аян;
- Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, гараас гарт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургуулийн орчинд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэх зорилго бүхий дүүргийн харьяа төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Хүүхдэд ээлтэй сургууль” 3 сарын аян;
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилго бүхий “Нэг удаа гэж үгүй” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Анзаар” 1 сарын аян;

Дээрх аян, арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлаас дурдвал:

“Зөвийг зөвлөө” нэгдсэн арга хэмжээний хүрээнд:

- Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архины зохисгүй хэрэглээг багасгах зорилгоор 3000 ширхэг зурагт хуудас;
- Тат, түлх зурагт хуудас 1000 ширхэг, автомашины арын наалт 15 ширхэг;
- АЗ хэмжээтэй зурагт самбар 50 ширхэг;

“Шийдвэрлэлт-2” арга хэмжээний хүрээнд:

- “Ногоон гэрэл-Цагаан шугам 2022” арга хэмжээ;

“Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд:

- “Зөв мод-Зөв арчилгаа” 2000 ширхэг зурагт хуудас;
- “Ногоон дуу хоолой-Бие даатал минь битгий орхиорой” 60,000 ширхэг гарын авлага;
- Хүнсний 4 дүгээр дэлгүүрийн хананд “Ногоон ирээдүйг бүтээцгээе” сэдэвт зураг
- Дүүргийн 16 дугаар хороонд байрлах 581 дүгээр ус түгээх худгийн хананд “Баярлалаа ааваа” сэдэвт зураг;
- “Ногоон дуу хоолой” 1 сарын аяны хүрээнд 17 төрлийн видео бичлэг, 23 төрлийн зурагт постер, 32 төрлийн мэдээ мэдээлэл бүхий зөвлөмж;

“Шийтгэл бол шийдэл биш” 1 сарын аяны хүрээнд:

- Үе тэнгийн дарамт, дээрэлхэлт, гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэл болгох зорилго бүхий өртөөчилсөн сургалтыг 1500 гаруй сурагчдын дунд зохион байгууллаа.

- Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудад “Хүүхдэд ээлтэй-Өрх гэр бүл”, “Хүүхдэд ээлтэй-Орон нутаг”, “Хүүхдэд ээлтэй-Боловсролын үйлчилгээ” сэдвүүдийн хүрээнд салбар хэлэлцүүлгийг зохион байгуулж, 27,000 гаруй сурагчдыг хамруулсан бөгөөд “Хүүхдийн дуу хоолой-2022” чуулганд тус хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг дүүргийн удирдлагуудад танилцууллаа.
- Аяны хугацаанд хүүхдийн дуу хоолойг сонсох, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын талаар гэр бүл, олон нийтийн зөв хандлагыг бий болгох чиглэлээр 5 удаагийн танхимын сургалтад 1800 гаруй сурагч, эцэг эх, асран хамгаалагчийг, 4 удаагийн хэлэлцүүлэг, чуулганд 27,000 гаруй сурагчдыг хамруулж, хүүхэд хамгааллын чиглэлээр 4 төрлийн шторк, 8 төрлийн постер мэдээллийг цахимаар түгээж, нийт 30,000 гаруй иргэдэд нөлөөллийн ажлыг хүргэсэн байна.

“Анзаар” 1 сарын аяны хүрээнд:

- “Нэг удаа гэж үгүй” зөвлөмж бүхий тараах материал 15,000 ширхэг;
- 21 төрлийн постер, 13 төрлийн видео шторк бэлтгэн тус арга хэмжээг сурталчилж, 286,574 хандалт авсан байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд болон хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх хүрээнд дараах байгууллагуудад техник, тоног төхөөрөмжийн туслалцаа, дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Үүнд:

- “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шаардлагатай техник, хэрэгслээр хангах хүрээнд 18 ширхэг таблетыг дүүргийн Прокурорын газарт;
- Дүүргийн Онцгой байдлын хэлтэст ой хээрийн түймэр, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, урьдчилан сэргийлэх, аврах, эрэн хайх ажиллагаанд ашиглагдах өндөр үзүүлэлт, хүчин чадал сайтай нисэх (дрон) төхөөрөмж, дагалдах хэрэгслийн хамт;
- Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын харьяа дүүрэг дэх Криминалистикийн шинжилгээний тасагт компьютер, өнгөт принтер, 3 ширхэг гэрэл зургийн аппарат;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах нөхцөлийг сайжруулах хүрээнд албан хэрэгцээнд ашиглагдах дрон, зургийн аппарат, дуран, энгэрийн микрофон;
- Зам тээврийн осол хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд энгэрийн камер хуулагч 1 ширхэг, Авто замын толь 5 ширхэг, шон 2 ширхгийг дүүрэг дэх Цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтэст;
- Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд шаардлагатай тоног төхөөрөмж, тог баригч;
- Дүүрэг дэх Цагдаагийн газрын 1 дүгээр хэлтэст 8 ширхэг сейф, принтер, сканер;

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн бүлгийн санал санаачилгыг дэмжих, хамтран ажиллах хүрээнд дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 19,7 га газрын 61 цэгт 145 камер шинээр байршуулж, “Ногоон бүс” төслийг хэрэгжүүллээ.

Уг төслийн хүрээнд Теле хяналтын нэгдсэн төвийг байгуулж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд суурилуулсан камеруудын дүрсийг нэгтгэж харах 25 ширхэг ханан дэлгэц, нэг дор 800 ширхэг камерын дэлгэцийг харах хүчин чадалтай, стандартад нийцсэн зориулалтын хана, шал, хөргүүр зэргийг цогцоор нь шийдсэн олон улсын жишигт нийцсэн, иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан “Ногоон бүс” бүхий хороог Чингэлтэй дүүрэгт байгууллаа.

Тайлант хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа, хамтарсан баг, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах үүрэг бүхий сайн дурын иргэдийн зөвлөлийг хороо тус бүрд иргэдийн зөвлөлийн ахлагч, 2 нарийн бичиг гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажиллах журмыг батлан, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Түүнчлэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил иргэд, олон нийтийг татан оролцуулах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах үйл ажиллагаанд туслах чиг үүрэг бүхий сайн дурын 400 иргэд гудамж, байрны нийтийн эргүүлээр ажиллаж байгаа бөгөөд сар бүр ажилласан байдлыг нь харгалзан мөнгөн шагналаар шагнаж урамшуулж байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба 2022 онд дэвшүүлсэн зорилтоо бүрэн хэрэгжүүлж, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүхий л талын дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Түүнчлэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч бүр Хурлын үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцож, дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилтыг жигд ханган биелүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсаныг талархан тэмдэглэж байна.

Цаашид дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хууль тогтоомж, хурлын шийдвэрийг сурталчлах, Хурлын хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба-Засаг даргын Тамгын газар хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, Төлөөлөгч-иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд голлон анхаарч, үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллах болно.

ХУРЛЫН АЖЛЫН АЛБА